

# **МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн дүрэм /цаашид “дүрэм” гэх/-ээр Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, хуралдааны дэг болон өөрийн удирдлагын хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Төрийн өмчийн болон төрийн өмчийн бус Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын /цаашид “сургалтын байгууллага” гэх/- Удирдах зөвлөл нь сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий хамтын удирдлагын байгууллага мөн.

1.3. Удирдах зөвлөл сургалтын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих, сургалтын байгууллагыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, санхүү, материаллаг баазыг бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл болон сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

1.4. Удирдах зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, бусад хууль тогтоомж болон энэхүү үлгэрчилсэн дүрмийг удирдлага болгоно.

1.5. Энэ үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн өөрийн дүрмээ боловсруулан баталж мөрдөнө.

## **Хоёр. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн**

2.1. Төрийн өмчийн сургалтын байгууллагын Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд төрийн төлөөлөл 5, түүнд багшийн 1 төлөөлөл орсон байх, мөн төрийн бус төлөөлөл нь суралцагч 1, төгсөгч 1, ажил олгогчийн төлөөлөл 2 тус тус бүрдсэн байна.

2.2. Төрийн өмчийн бус сургалтын байгууллага санал болгосон бол Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 1/3 нь төрийн төлөөлөл байж болно.

2.3. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараах байдлаар томилно.

2.3.1. төрийн өмчийн сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн бус төлөөллийг тус сургалтын байгууллагын хамт олны саналыг үндэслэн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолоор баталгаажуулна.

2.3.2. төрийн өмчийн бус сургалтын байгууллагын дүрэмд өөрөөр заагаагүй бол Удирдах зөвлөлд төрийн төлөөлөл оруулж болох бөгөөд гишүүдийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

2.4. Удирдах зөвлөл дэх багш суралцагчийн төлөөллийг хамт олны 50-аас доошгүй ирцтэй хурлаас олонх /50-аас дээш хувь/-ийн саналаар шийдвэрлэнэ.

2.5. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, чадваржуулах, дадлага ажил, үйлдвэрийн сургалт зохион байгуулах чиглэлээр түншилж, санхүүгийн дэмжлэг үзүүлж, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагаас ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг сонгоно.

2.6 Удирдах зөвлөлийн гишүүдийг 3 жилийн хугацаагаар томилох ба дахин нэг удаа улираан томилж болно. Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх бичгээр гаргасан хүсэлт болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хугацаанаас нь өмнө өөрчилж болно.

2.7 Удирдах зөвлөлийн даргыг үүсгэн байгуулагчийн санал болгосноор 3 жилийн хугацаагаар Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаас ил санал хураалтаар сонгоно.

2.8 Удирдах зөвлөлийн ажлын албаны үүргийг сургалтын байгууллага гүйцэтгэж, зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

2.9 Удирдах зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь тухайн сургалтын байгууллагын захиргааны асуудал хариуцсан ажилтан байна.

## **Гурав. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа**

3.1. Удирдах зөвлөл нь Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэр болон хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, санал гаргах;

3.1.2. сургалтын байгууллагын батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан зохион байгуулалт, үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх;

3.1.3. бүс орон нутгийн хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, ажил олгогчийн хэрэгцээ, захиалгад нийцүүлэн сургалтын байгууллагын элсэлт, сургалт, төгсөлтийг зохион байгуулах, төгсөгчдийг ажлын байртай холбоход чиглэсэн үйл ажиллагааг хэлэлцэн, холбогдох шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;

3.1.4. хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг батлах, зарцуулалтад хяналт тавих;

3.1.5. сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох шийдвэр гаргах;

3.1.6. суралцагчдын эрх ашгийг хамгаалах

3.1.7. удирдах зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайланг үүсгэн байгуулагчид бичгээр тайлагнах;

3.1.8. нийгмийн түншлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавих

3.1.9. хууль тогтоомж, дүрэмд заасан бусад чиг үүрэг.

3.2. Удирдах зөвлөл өөрийн үйл ажиллагаанд тусгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болох бөгөөд үүнийг Удирдах зөвлөлийн гишүүн ахална.

3.3. Удирдах зөвлөлийн дарга дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1. удирдах зөвлөлийг хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлыг үүсгэн байгуулагч болон сургуулийн захиралтай зөвшилцөн товлох;

3.3.2. удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргад ажил үүргийн хуваарийг тогтоох, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх

3.3.3. удирдах зөвлөлөөс томилсон ажлын хэсгийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.3.4. удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны үнэлэлт, дүгнэлтийг эрх бүхий этгээдэд мэдээлэх;

3.3.5. хууль тогтоомж, дүрэмд заасан бусад чиг үүрэг.

3.4 Удирдах зөвлөлийн гишүүн дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1 удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, зөвлөлийн дарга хуралдаанд мэдээлэх, тайлагнах;

3.4.2. удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудал, хуралдааны дэг, шийдвэрийн талаар санал, дүгнэлтээ хэлэх;

3.4.3. удирдах зөвлөлөөс хариуцуулсан ажил үүргийг бүрэн биелүүлэх, үр дүнг танилцуулах;

3.4.4. удирдах зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, холбогдох мэдээлэл авах;

3.3.5. удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих, тайлбар гаргуулах, асуудал хэлэлцүүлэх;

3.4.6. хууль тогтоомж, дүрэмд заасан бусад чиг үүрэг.

3.5. Төрийн өмчийн бус сургалтын байгууллагын дүрэмд өөрөөр заагаагүй бол энэхүү Үлгэрчилсэн дүрмийн 3.1.2, 3.1.4-т заасан чиг үүрэг хамаарахгүй.

### **Дөрөв. Удирдах зөвлөлийн хуралдаан**

4.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд гишүүдийн 50- аас дээш хувь нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно.

4.2. Удирдах зөвлөл хэлэлцүүлэх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Удирдах зөвлөлийн дарга тогтоолд гарын үсэг зурж, сургалтын байгууллагын тэмдэг дарж баталгаажуулна. Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлнө.

4.3. Удирдах зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Ээлжит бус хуралдааныг үүсгэн байгуулагчийн санаачилга, эсхүл гишүүдийн 1/3-ээс доошгүйн шаардсанаар хуралдуулна.

4.4. Удирдах зөвлөлийн хуралдааны товыг 7-оос доошгүй хоногийн өмнө зарлаж, нарийн бичгийн дарга нь холбогдох материалыг гишүүдэд хүргэнэ.

4.5. Удирдах зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Түүнийг эзгүйд удирдах зөвлөлийн даргын томилсон эсхүл хуралдаанд оролцох гишүүдийн олонхын санал авсан гишүүн даргална.

4.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг хуралдаан даргалагчийн саналыг харгалзан хэлэлцэж тогтооно.

4.7. Удирдах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үүсгэн байгуулагч 1 удаа түдгэлзүүлж болно. Энэ тохиолдолд Удирдах зөвлөл дахин авч үзэж, эцэслэн шийдвэрлэнэ.

4.8. Удирдах зөвлөлийн хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан сургалтын байгууллагын эрх бүхий ажилтан, багш, суралцагчийн төлөөллийг оролцуулан санал, хүсэлт, тайлбарыг сонсож, мэдээлэл авч болно.

4.9. Хуралдаанаар зөвхөн хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлыг хэлэлцэнэ.

4.10. Хэлэлцэх асуудалтай холбогдолтой мэдээлэл, танилцуулга тайлбарыг асуудал оруулан хэлэлцүүлж байгаа гишүүн хийх бөгөөд холбогдох материалыг урьдчилан тараасантай холбогдуулан гишүүдээс асуулт, санал дүгнэлт гаргаагүй бол шууд санал хураалт явуулж болно.

4.11. Хуралдаан явагдаж байгаа үед бусдын яриаг таслах, зэрэгцэн ярихыг хориглох бөгөөд асуулт тавих, санал гаргах бүрд хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авч байна.

4.12. Удирдах зөвлөлийн гишүүд хуралдаанд оролцогчдын асуух асуулт, үг хэлэх хугацааг хуралдааны дотоод журмаар тогтоох бөгөөд зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, товч тодорхой байна.

4.13. Удирдах зөвлөлийн хуралдаанд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр нэг саналын эрхтэй байна. Харин хуралдааны ирц буюу бусад шалтгаанаар санал тэнцсэн тохиолдолд Удирдах зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.14. Удирдах зөвлөлийн хуралдаанд оролцох боломжгүй гишүүн нь тухайн хэлэлцэх асуудлаар саналаа бичгээр ирүүлсэн тохиолдолд түүнийг хуралдаанд сонсгож хэлэлцүүлэх бөгөөд асуудлыг дэмжсэн болон эсрэг санал өгсөн бол хуралд оролцож санал өгсөнд тооцно.

## **Тав . Удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчийн хамтын ажиллагаа**

5.1. Удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа явц, үр дүнг үүсгэн байгуулагчийн өмнө тайлагнана. Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын талаар үүсгэн байгуулагчтай зөвшилцөж ажиллана.

5.2. Үүсгэн байгуулагч нь Удирдах зөвлөл дэх өөрийн төлөөллийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай бол энэ дүрмийн 2.6-д заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

## **Зургаа. Бусад зүйл**

6.1. Удирдах зөвлөл нь зөвлөлийн тогтоол, хуралдааны тэмдэглэлийн хэвлэмэл хуудастай байна. Удирдах зөвлөлийн албан хэрэгт сургалтын байгууллагын тэмдгийг хэрэглэнэ.

6.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, албан томилолтын болон бусад зардлыг сургалтын байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулсан байна.